



**ЗАВХАН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/16

Улиастай

Эзэмшил газрыг хэсэгчилж нийтийн  
эзэмшилд шилжүүлэх тухай


Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Улиастай сумын 1-р баг Жинст, Дилав Хутагт Жамсранжавын 1-110А тоотод байрлалтай иргэн (ИЭ67011810) регистрийн дугаартай Цэцэн Шалгууд овогтой Жанчивдэчингийн Буянтогтохын эзэмшлийн орон сууцны зориулалттай 3157 кв.м газрын 1100 кв.м газарт 4 ба түнээс доош давхар нийтийн орон сууц ашиглалтанд оруулж улсын комисс хүлээж авсан тул 1100 кв.м газрыг нийтийн эзэмшилд шилжүүлсүгэй.

2.Нийтийн эзэмшилд шилжсэн газрын тохижилтыг батлагдсан зураг төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөх мөн үлдсэн 2057 кв.м газарт эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээг олгон, газрын төлбөрийн ногдуулалтыг хийж эзэмшүүлсэн газрын хил заагийг тэмдэгжүүлэн баталгаажуулж, актаар хүлээлгэн өгөхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Анхтэс)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2020 оны 10 сарын 13-ны өдрийн А/383 дугаар захирамжийн Ж.Буянтогтоход холбогдох хэсэгт тэмдэглэл хийхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (У.Батдаваа)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Р.ӨНӨРБАЯР

8109010079